

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Увс аймгийн Мал эмнэлгийн газрын 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: УВА-2026/084/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Улаанбаатар хот
2026 он

Увс аймаг дахь Төрийн аудитын газар,
Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь
Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn
Аудитын менежер: М.Бат-Амгалан
Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn
Аудитор: Р.Аюуш
Утас: 70453799
Цахим хаяг: Ayushr@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	12
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	12
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	13
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт.....	13
3.5 Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	14
4. Аудитын тайлан.....	16
4.1 Ерөнхий зүйл	16
4.2 Материаллаг байдал	16
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
5. Аудитын илрүүлэлт	18

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт





УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, Ө.Бадрахын гудамж
3 дугаар баг, Улаангом сум, Увс аймаг, 85165,

Утас/факс: 7045-3317,

Цахим шуудан: uvs@audit.gov.mn

2026.02.03 № УВА-2026/084/НА-СТА-ТЧЗ
танай _____-ны № _____-т

МАЛ ЭМНЭЛГИЙН ГАЗРЫН
ДАРГА Д.ГАНХУЯГ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Увс аймгийн Мал эмнэлгийн газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Мал эмнэлгийн газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

АДБОУС 2706.7-д тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

Бусад асуудлын хэсэг

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад санхүүгийн тайлангийн тодруулга толилуулгад тусгаагүй, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй асуудал гараагүй болно.

8525050060

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М. БАТСУУРЬ

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	443,037,625.0	599,505,307.00
33	АВЛАГА	-	384,305,311.00
335	Бусад авлага	-	384,305,311.00
333000	Татаас санхүүжилтийн авлага		2,827,661.00
3354	Салбараас авах авлага	-	381,477,650.0
35	БАРАА МАТЕРИАЛ	443,037,625.0	215,199,996.0
351	Түүхий эд материал	381,569,800.8	137,826,871.7
35110	Тусгай зориулалттай материал	17,439,505.2	11,168,499.9
35130	Эм боох материал	364,130,295.6	126,658,371.8
354	Хангамжийн материал	61,467,824.2	77,373,124.3
35410	Бичиг хэргийн материал	5,104,667.0	3,862,967.1
35420	Аж ахуйн материал	16,554,141.0	10,178,641.0
35470	Бусад хангамжийн материал	39,809,016.2	63,331,516.20
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	608,018,825.8	716,691,832.26
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	608,018,825.8	716,691,832.26
392	Биет хөрөнгө	565,452,825.8	692,599,582.26
39201	Барилга, байгууламж, орон сууц	163,732,941.5	163,732,941.5
39202	Хуримтлагдсан элэгдэл	(50,459,834.2)	(55,455,902.39)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	369,549,371.0	369,549,371.0
39204	Хуримтлагдсан элэгдэл	(170,869,163.9)	(206,279,944.55)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	517,961,907.3	796,764,165.25
39206	Хуримтлагдсан элэгдэл	(293,704,579.7)	(402,272,085.27)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	52,760,656.1	55,931,056.09
39208	Хуримтлагдсан элэгдэл	(23,518,472.2)	(29,370,019.40)
393	Биет бус хөрөнгө	42,566,000.0	24,092,250.0
39301	Програм хангамж	1,980,000.0	1,980,000.0
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,980,000.0)	(453,750.0)
39303	Бусад биет бус хөрөнгө	42,566,000.0	22,566,000.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,051,056,450.8	1,316,197,139.26
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	897,774,856.59
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	897,774,856.59
413	Өглөг	-	-
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	10,594,583.53
41360	Бусад өглөг	-	887,180,273.06
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,051,056,450.8	418,422,282.67
51	Засгийн газрын хувь оролцоо	1,051,056,450.8	22,566,000.0
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	22,566,000.0	22,566,000.0
51101	Өмч: - төрийн	22,566,000.0	22,566,000.0
512	Хуримтлагдсан үр дүн	1,028,490,450.8	393,028,621.67
51210	Өмнөх үеийн үр дүн	833,077,698.5	1,028,490,450.8
51220	Тайлант үеийн үр дүн	195,412,752.3	(632,634,168.13)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,051,056,450.8	1,316,197,139.26



2.2. Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/


Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	4,503,103,374.97	4,922,428,708.55
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,189,384,380.6	1,269,034,308.55
120	Нийтлэг татварын бус орлого	755,860,080.88	1,269,034,308.55
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	755,860,080.88	1,269,034,308.55
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,886,600.0	4,327,661.0
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	753,973,480.9	1,264,706,647.55
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,747,243,294.1	3,653,094,400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,916,615,600.0	1,918,795,100.0
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,916,615,600.0	1,918,795,100.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,830,627,694.09	1,734,299,300.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	834,436,994.1	1,132,370,700.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	994,755,200.0	601,508,600.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,435,000.0	
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	4,297,690,622.7	5,534,342,876.68
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,297,690,622.7	5,534,342,876.68
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,935,884,361.0	5,318,621,206.04
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,154,072,098.2	1,408,797,106.45
210101	Үндсэн цалин	711,930,147.2	819,384,280.97
210102	Нэмэгдэл	340,440,628.6	428,040,543.98
210103	Унаа хоолны хөнгөлөлт	41,668,000.0	67,207,500.0
210104	Урамшуулал	60,033,322.4	94,164,781.50
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	156,505,872.3	182,321,006.04
210201	Тэтгэврийн даатгал	100,367,309.5	117,011,629.17
210202	Тэтгэмжийн даатгал	12,377,806.6	14,015,580.48
210203	ҮОМШӨ-ний даатгал	15,911,404.7	17,218,850.79
210204	Ажилгүйдлийн даатгал	5,993,793.0	7,295,776.70
210205	Эрүүл мэндийн даатгал	21,855,558.5	26,779,168.90
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	43,905,379.3	58097,356.06
210301	Гэрэл, цахилгаан	4,630,549.3	6,359,856.06
210302	Түлш, халаалт	29,004,360.0	42,380,800.0
210303	Цэвэр, бохир ус	1,825,470.0	3,506,700.0
210304	Байрны түрээс	8,445,000.0	5,850,000.0
2104	Хангамж, бараа материалын зардал	54,572,370.0	49,540,036.0
210401	Бичиг хэрэг	3,356,800.0	6,247,080.0
210402	Тээвэр, шатахуун	39,624,112.0	27,443,683.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,024,958.0	2,394,673.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,180,000.0	0.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,386,500.0	13,034,600.0
2105	Нормативт зардал	785,221,966.9	1,832,145,723.61
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	785,221,966.9	1,832,145,723.61
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	985,000.0
210604	Урсгал засвар	-	985,000.0
2107	Томилолт, зочны зардал	44,007,000.0	14,470,000.0

210702	Дотоод албан томилолт	44,007,000.0	14,470,000.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,506,061,266.0	1,571,827,921.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,495,855,222.0	1,563,526,920.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,422,000.0	-
210803	Даатгалын үйлчилгээ	-	586,980.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	369,044.0	760,521.0
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	55,000.0	33,500.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7,860,000.0	6,420,000.0
210807	Газрын төлбөр	500,000.0	500,000.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	191,538,408.36	200,857,056.88
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	17,445,035.60	33,325,905.30
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	250,000.0	180,000.0
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	173,843,372.76	167,351,151.58
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	361,806,261.68	218,549,331.64
2132	Бусад урсгал шилжүүлэг	190,595,131.0	190,595,131.0
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	7,676,000.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	57,019,600.0	106,783,593.01
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	133,025,531.0	76,478,999.94
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	550,000.0	0.0
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	171,211,130.68	27,610,738.69
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	167,219,730.68	8,824,306.02
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	3,991,400.0	15,958,771.60
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	10,000,000.0	20,000,000.0
2200	Дотоод эх үүсвэрээр	10,000,000.0	20,000,000.0
225001	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз) /ТӨҮГ/	0.0	20,000,000.0
225101	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз) /ТӨҮГ/	10,000,000.0	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	195,412,752.3	(632,634,168.13)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	195,412,752.3	(632,634,168.13)

2.3. Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	3,749,129,894.1	3,657,422,061.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,886,600.0	4,327,661.0
120	Нийтлэг татварын бус орлого	1,886,600.0	4,327,661.0
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,886,600.0	4,327,661.0
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,886,600.0	4,327,661.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,747,243,294.1	3,653,094,400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,916,615,600.0	1,918,795,100.0
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,916,615,600.0	1,918,795,100.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,830,627,694.1	1,734,299,300.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	834,436,994.1	1,132,370,700.0



131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	994,755,200.0	601,508,600.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,435,500.0	420,000.0
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	3,717,282,494.1	3,414,422,061.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,717,282,494.1	3,414,422,061.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,353,976,232.4	3,201,489,914.36
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,153,872,098.2	1,396,000,015.61
210101	Үндсэн цалин	711,730,147.2	804,908,915.55
210102	Нэмэгдэл	340,440,628.6	429,695,132.81
210103	Унаа хоолны хөнгөлөлт	41,668,000.0	67,231,185.75
210104	Урамшуулал	60,033,322.4	94,164,781.50
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	156,649,820.9	184,523,513.35
210201	Тэтгэврийн даатгал	100,511,258.1	118,376,493.59
210202	Тэтгэмжийн даатгал	12,377,806.6	14,059,973.81
210203	ҮОМШӨ-ний даатгал	15,911,404.7	17,282,101.87
210204	Ажилгүйдлийн даатгал	5,993,793.0	7,317,203.85
210205	Эрүүл мэндийн даатгал	21,855,558.5	27,487,740.23
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	44,012,379.3	57,380,900.0
210301	Гэрэл, цахилгаан	4,630,549.3	6,248,500.0
210302	Түлш, халаалт	29,004,360.0	42,380,800.0
210303	Цэвэр, бохир ус	1,932,470.0	2,901,600.0
210304	Байрны түрээс	8,445,000.0	5,850,000.0
2104	Хангамж, бараа материалын зардал	53,645,360.0	23,043,875.0
210401	Бичиг хэрэг	5,553,490.0	2,140,150.0
210402	Тээвэр, шатахуун	39,559,112.0	14,662,552.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,024,958.0	1,987,673.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,180,000.0	0.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,327,800.0	4,253,500.0
2105	Нормативт зардал	368,872,358.0	388,326,140.40
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	368,872,358.0	388,326,140.40
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	26,380,950.0	37,492,400.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	940,000.0	629,900.0
210605	Хөдөлмөр хамгаалах хэрэгсэл	-	19,140,000.0
+210604	Урсгал засвар	25,440,950.0	17,722,500.0
2107	Томилолт, зочны зардал	44,007,000.0	14,470,000.0
210702	Дотоод албан томилолт	44,007,000.0	14,470,000.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,506,061,266.0	1,097,490,070.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,495,855,222.0	1,090,456,570.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,422,000.0	-
210803	Даатгалын үйлчилгээ	-	580,000.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	369,044.0	-
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	55,000.0	33,500.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7,860,000.0	6,420,000.0
210807	Газрын төлбөр	500,000.0	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	475,000.0	2,763,000.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	475,000.0	2,763,000.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	363,306,261.7	196,981,624.57
2132	Бусад урсгал шилжүүлэг	192,095,131.0	185,321,407.95
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж урамшуулал	-	7,676,000.0



213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	57,019,600.0	101,166,408.01
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	133,025,531.0	76,478,999.94
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,050,000.0	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	171,211,130.7	27,610,738.69
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	171,211,130.7	11,660,216.62
213305	Нэмэлт төсвийн төвлөрүүлэх шилжүүлэг	3,991,400.0	15,958,771.60
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>31,847,400.0</u>	<u>243,000,000.0</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	31,847,400.0	243,000,000.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	31,847,400.0	243,000,000.0
2200	Дотоод эх үүсвэрээр	31,847,400.0	243,000,000.0
225101	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн /ТӨҮГ/	10,000,000.0	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	21,847,400.0	43,000,000.0
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(31,847,400.0)</u>	<u>243,000,000.0</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	0.00	0.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

2.4. Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

						<i>/төгрөгөөр/</i>
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	22,566,000.00	0.00	833,077,698.52	0.00	855,643,698.52
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	22,566,000.00	0.00	833,077,698.52	0.00	855,643,698.52
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00	0.00
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	195,412,752.28	0.00	195,412,752.28
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	22,566,000.00	0.00	1,028,490,450.80	0.00	1,051,056,450.80




D01	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	22,566,000.00	0.00	1,028,490,450.80	0.00	1,051,056,450.80
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	22,566,000.00	0.00	1,028,490,450.80	0.00	1,051,056,450.80
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00	0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					0.00
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	(632,634,168.13)	0.00	(632,634,168.13)
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	22,566,000.00	0.00	395,856,282.67	0.00	418,422,282.67

2.5. Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,000,850,376.0	1,911,470,794.0	89,379,582.0	95.5%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,000,850,376.0	1,911,470,794.0	89,379,582.0	95.5%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,797,278,176.0	1,726,149,386.03	71,128,789.97	96.0%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,351,180,300.0	1,344,873,853.49	6,306,446.51	99.5%
210101	Үндсэн цалин	856,150,100.0	804,908,915.55	51,241,184.45	94.0%
210102	Нэмэгдэл	332,563,800.0	378,568,970.69	(46,005,170.69)	113.8%
210103	Унаа хоолны хөнгөлөлт	63,157,300.0	67,231,185.75	(4,075.885.75)	106.5%
210104	Урамшуулал	99,309,100.0	94,164,781.50	5,144,318.50	94.82%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	177,085,000.0	177,084,997.54	2.46	100%
210201	Тэтгэврийн даатгал	116,685,700.0	113,638,006.98	3,047,693.02	97.4%
210202	Тэтгэмжийн даатгал	14,139,600.0	13,502,504.73	637,095.27	95.5%
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,973,400.0	16,489,627.14	(5,516,227.14)	150.3%
210204	Ажилгүйдлийн даатгал	7,057,200.0	7,047,179.21	10,020.79	99.9%
210205	Эрүүл мэндийн даатгал	28,229,100.0	26,407,679.48	1,821,420.52	93.6%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	57,380,900.0	57,380,900.0	-	100%
210301	Гэрэл, цахилгаан	6,246,800.0	6,248,500.0	(1,700)	100%
210302	Түлш, халаалт	42,382,500.0	42,380,800.0	1,700.0	100%



210303	Цэвэр, бохир ус	2,901,600.0	2,901,600.0	-	100%
210304	Байрны түрээс	5,850,000.0	5,850,000.0	-	100%
2104	Хангамж, бараа материалын зардал	21,438,300.0	18,739,275.0	2,699,025.0	87.41%
210401	Бичиг хэрэг	1,995,900.0	1,920,150.0	75,750.0	96.21%
210402	Тээвэр, шатахуун	12,813,200.0	12,777,952.0	35,248.0	99.73%
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,996,400.0	1,987,673.0	8,727.0	99.56%
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,404,000.0	-	1,404,000.0	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,228,800.0	2,053,500.0	1,175,300.0	63.6%
2105	Нормативт зардал	669,100.0	491,260.0	177,840.0	73.42%
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	669,100.0	491,260.0	177,840.0	73.42%
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	34,321,100.0	37,492,400.0	(3,171,300.0)	109.2%
210601	Багаж, техник, хэрэгсэл	676,300.0	629,900.0	46,400.0	93.14%
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	19,996,100.0	19,140,000.0	856,100.0	95.7%
210604	Урсгал засвар	13,648,700.0	17,722,500.0	(4,075,800.0)	129.8%
2107	Томилолт, зочны зардал	11,114,000.0	11,770,000.0	(656,000.0)	105.9%
210702	Дотоод албан томилолт	11,114,000.0	11,770,000.0	(656,000.0)	105.9%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	139,893,076.0	75,553,700.0	64,339,376.0	54.0%
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	128,789,676.0	68,520,200.0	60,269,476.0	53.2%
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,562,300.0	-	2,562,300.0	-
210803	Даатгалын үйлчилгээ	580,000.0	580,000.0	-	100.0%
210804	Тээврийн хэрэгслийн татвар	508,300.0	-	508,300.0	-
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	118,400.0	33,500.0	84,900.0	28.3%
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7,200,000.0	6,420,000.0	780,000.0	89.17%
210807	Газрын төлбөр	134,400.0	-	134,400.0	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,196,400.0	2,763,000.0	1,433,400.0	65.8%
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,196,400.0	2,763,000.0	1,433,400.0	65.8%
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	203,572,200.0	185,321,407.95	18,250,792.05	91.0%
2132	Бусад урсгал шилжүүлэг	203,572,200.0	185,321,407.95	18,250,792.05	91.0%
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж урамшуулал	15,396,000.0	7,676,000.0	7,720,000.0	49.9
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	101,704,200.0	101,166,408.01	537,791.99	99.5%
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	83,322,000.0	76,478,999.94	6,843,000.06	91.8%
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,150,000.0	-	3,150,000.0	-
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,999,350,376.0	1,999,350,376.0	(386,600.0)	100.0%
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,999,350,376.0	1,999,350,376.0	-	100.0%
122005	Улсын төсвөөс	1,999,350,376.0	1,999,350,376.0	-	100.0%
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,500,000.0	4,327,661.0	0.0	0.0
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,500,000.0	4,327,661.0	0.0	0.0
6	Төсвийн бусад мэдээллийн ангилал				
62	Ажиллагсдын тоо	49	40	9	
620001	Удирдах ажилтан	1	1	0	
620002	Гүйцэтгэх ажилтан	44	35	9	

620003	Үйлчлэх ажилтан	4	4	0
--------	-----------------	---	---	---

2.6. Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,717,920,528.33
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,717,920,528.33
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,717,920,528.33
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	51,126,162.12
210102	Нэмэгдэл	51,126,162.12
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	7,438,515.81
210201	Тэтгэврийн даатгал	4,738,486.61
210202	Тэтгэмжийн даатгал	557,469.08
210203	ҮОМШӨ-ний даатгал	792,474.73
210204	Ажилгүйдлийн даатгал	270,024.64
210205	Эрүүл мэндийн даатгал	1,080,060.75
2104	Хангамж, бараа материалын зардал	3,884,600.00
210402	Тээвэр, шатахуун	1,884,600.00
210405	Бага үнэтэй түргэн элэгдэх зүйлс	2,000,000.00
2105	Нормативт зардал	387,834,880.40
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	387,834,880.40
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	243,000,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	243,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	2,700,000.00
210702	Дотоод албан томилолт	2,700,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,021,936,370.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,021,936,370.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,717,920,528.33
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,717,920,528.33
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,116,411,928.33
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	601,508,600.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Увс аймгийн Мал эмнэлгийн газар нь мал амьтны өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, мал аж ахуйн гаралтай хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын баталгааг хангах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллага юм.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг явуулж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан



- авах тухай хууль
- Мал эмнэлгийн тухай хууль
- Мал амьтны эрүүл мэндийн тухай хууль
- Шилэн дансны тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- ✓ Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 2024 оны 10 дугаар сарын 7-ны өдрийн 3 дугаар тогтоолоор улсын хэмжээнд мөрдөх хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн сард 792.0 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоосон.
- ✓ Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 238 дугаар тогтоолоор Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон.
- ✓ Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн А/3 дугаар тогтоолоор батлагдсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"
- ✓ Төрийн хэмнэлтийн тухай хуульд - 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр, 2024 оны 06 дугаар сарын 16-ны өдөр, 07 дугаар сарын 07-ны өдөр, 2024 оны 12 дугаар сарын 12-ны өдөр,

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Увс аймгийн Мал эмнэлгийн газрын 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.


Увс аймгийн Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны сайдын 2022 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн А/359 дүгээр тушаалаар батлуулсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг жишиг болгон мөрдөж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Увс аймгийн Мал эмнэлгийн газрын 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 262,313.0 мянган төгрөгөөр бууу 20 хувиар өссөн байна.



Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	384,305.3	384,305.3
Бараа материал	443,037.6	215,200.0	(227,837.6)
Үндсэн хөрөнгө	608,018.8	716,691.8	108,673.0
Нийт хөрөнгө	1,051,056.4	1,316,197.1	265,140.7
Өр төлбөр	-	897,774.9	897,774.9
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,051,056.4	418,422.2	(632,634.2)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,051,056.4	1,316,197.1	265,140.7

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэлгүй байна.

Авлага дансны үлдэгдэл 384,305.3 мянган төгрөгөөр өссөн нь татаас санхүүжилтийн авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 215,200.0 мянган төгрөг болж 227,837.6 мянган төгрөгөөр буурсан нь эм боох материал, тусгай зориулалтын материал, аж ахуйн материал, бичиг хэргийн материал буурсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн данс 716,691.8 мянган төгрөг болж 108,673.0 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 43,629.9 мянга, Мал эмнэлгийн ерөнхий газраас 8,541.0 мянган төгрөгийн хөрөнгө шилжиж ирж, Мал эмнэлгийн үйлчилгээний төслөөс 33,873.3 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүйгээр хүлээн авч, 9,980.0 мянган төгрөгийн хөрөнгийг дахин үнэлгээ хийсэнтэй холбоотой байна. Тайлант онд 167,351.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал тооцсон байна.

Өр төлбөрийн данс 897,774.9 мянган төгрөгөөр өссөн нь ажилчидтай холбогдсон өглөг 10,594.6 мянга, байгууллагад төлөх өглөг 881,563.1 мянга, хувь хүмүүст төлөх өглөг 5,617.2 мянган төгрөгөөр тус тус өссөнтэй холбоотой байна. Тайлант онд үүссэн өглөгүүд татаас санхүүжилттэй холбоотойгоор үүссэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 418,422.2 мянган төгрөг болж 632,634.2 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт


Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 2,048,191.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Улсын төсвөөс зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 240,151.9 мянган төгрөгөөр бууруулж нийт зардлыг 1,910,790.0 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 90,060.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 2,000,850.4 мянган төгрөг болгон тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,999,350.4 мянган төгрөгийг улсын төсвөөс, 1,500.0 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,907,143.1 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 4,327.7 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд улсын төсвийн 1,911,470.8 мянган төгрөгийг зарцуулсан байна.



Тайлант оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэлийн тайлангийн батлагдсан төлөвлөгөөг Сангийн яамнаас 69,837.1 мянган төгрөгөөр бууруулсан дүнгээр тайлагнасан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөг/

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Үндсэн үйл ажиллагааны зардал /80101/	1,681,988.5	1,677,739.6	4,248.9	99.7%
2	Малын гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх /82506/	38,316.2	38,316.1	0.1	100%
3	Мал, амьтан эрүүлжүүлэх /82548/	14,660.4	14,660.3	0.1	100.0%
4	Ажил олгогчоос олгох тэтгэмж /80802/	195,874.2	188,471.4	7,402.8	96.2%
5	Төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх /81569/	15,544.1	15,544.0	0.1	100%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Аудитын ерөнхий чиглэлийн судалгааны дүн

/мянган төгрөг/

№	Үзүүлэлт	Төсөвлөсөн	Гүйцэтгэл	Зөрүү	Тайлбар
1	Программ хангамжийн бүртгэл	660.0	660.0	-	Динамик программын санхүүгийн тайлан дахь бүртгэлийн дүн 1,980.0 мянга, тайланд онд 660.0 мянган төгрөгийн засвар үйлчилгээний төлбөр төлсөн байна.
2	Унаа, хоолны зардал	63,157.3	67,231.2	(4,073.9)	Байгууллагын дотоод журам, Газрын даргын 2025 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн А/02 дугаар тушаалаар унаа, хоолны хөнгөлөлтийг аймгийн төвд 5.0 мянгаас 10.0 мянга, сумын албан хаагчид 2.5 мянгаас 5.0 мянган төгрөг болгон нэмэгдүүлсэн нь 4.073.9 мянган төгрөгөөр нэмэгдэхэд нөлөөлсөн байна.
3	Сургалт, семинар, хурал, зөвлөгөөний зардал	4,196.4	2,763.0	1,433.4	Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусадсаны дагуу салбарын албан хаагчдыг чадвахижуулах, төрийн албан хаагчийн ёс зүйн сургалтад зардал гарсан байна.
4	Гадаад томилолт, арга хэмжээ	0.00	0.00	0.00	Гадаад томилолт, арга хэмжээ зардал гараагүй байна.
5	Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардал	0.00	0.00	0.00	Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардал гараагүй байна.
6	Орон тоо	56	49	7	ХХААХҮ-ийн сайдын 2025 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн А/342 дугаар тушаалаар 7 орон тоог хасаж 49 бүтэц, орон тоо баталсныг хэрэгжүүлэн ажилласан байна.
7	Хэвлэл мэдээлэл	0.00	0.00	0.00	Хэвлэл мэдээлэлтэй холбоотой зардал гараагүй байна.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн



бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 601,508.6 мянга, орон нутгийн төсвөөс 1,116,411.9 мянга, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 420.0 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилт авснаас бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардалд 1,021,936.4 мянга, норматив зардалд 387,834.9 мянга, цалин хөлс болон нэмэгдэл урамшил зардалд 51,126.2 мянга, нийгмийн даатгалын шимтгэлд 7,438.5 мянга, хангамж, бараа материалын зардалд 4,304.6 мянга, багаж, техник, хэрэгслийн зардалд 243,000.0 мянга, томилолтын зардалд 2,700.0 мянган төгрөгийг тус тус зарцуулж төсөвт 15,958.8 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй байна.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд орон нутгийн санхүүжилтээр 250,000.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй “Зөөврийн хөргүүр 10 тн” худалдан авахаар нээлттэй тендер шалгаруулалтыг цахимаар зарлан 243,000.0 мянган төгрөгийн гэрээний дүнгээр худалдан авах ажиллагааг зохион байгуулж, гэрээнд заасан хугацаанд хүлээн авч данс бүртгэлд тусган ажилласан байна.

Мөн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор 629.9 мянган төгрөгийн багаж техник хэрэгслийн зардлаас, 472,362.9 мянган төгрөгийн бараа материалыг шууд худалдан авсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Увс аймгийн Мал эмнэлгийн газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Р.Аюуш гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Увс аймгийн Мал эмнэлгийн газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 16 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны төсвийн нийт зардлын 4,503,103.4 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 45,031.0 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.



Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг 2025 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 5,521,640.0 мянган төгрөгийн 1 хувиар 55,216.4 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 44,173.1 мянган төгрөгөөр тогтоолоо. Материаллаг байдлыг шинж чанарын хувьд авч үзээгүй болно.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Увс аймгийн Мал эмнэлгийн газрын төсөв захирагчийн тухайн хуульд хамаарах зүйл заалтын хүрээнд горим сорил хэрэгжүүлсэн. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Төрийн аудитын байгууллагаас 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитаар баримтлах ерөнхий чиглэлд тусгагдсан болон бусад хууль тогтоомжтой холбоотой хэрэгжүүлсэн горим сорилын хүрээнд зөрчил илрээгүй болно.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 2,066,703.7 мянган төгрөгийн 25 мөнгөн гүйлгээ, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 1,799,143.5 мянган төгрөгийн 101 мөнгөн гүйлгээг, бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийн 165,617.4 мянган төгрөгийн 19 шийдвэрийг хугацаа хоцроож, 2,769,236.5 мянган төгрөгийн 23 шийдвэрийг шилэн дансны цахим хуудаст байршуулаагүй нь Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байсанд зөвлөмж өглөө.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Төрийн аудитын байгууллагаас 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитаар баримтлах ерөнхий чиглэлд тусгагдсан болон бусад хууль тогтоомжтой холбоотой хэрэгжүүлсэн горим сорилын хүрээнд зөрчил илрээгүй болно.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Увс аймгийн Мал эмнэлгийн газрын 2025 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1,055.6 мянган төгрөгийн төлбөрийн актыг барагдуулсан байна.

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	1,055.6	1	1,055.6	100%
Албан шаардлага					
Зөвлөмж					100%
Нийт дүн	1	1,055.6	1	1,055.6	100%

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Мал эмнэлгийн газрын нягтлан бодогчид Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэгт “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагын шийдвэрээр нягтлан бодох бүртгэлийн ажилтанд мэргэшсэн эрхийн нэмэгдэл олгож болно” гэж заасныг үндэслэн татварын мэргэшсэн зөвлөхийн мэргэшлийн зэргийн нэмэгдлийг 40 хувиар 3,113.9 мянган төгрөгийг олгосон байна. Мэргэшлийн зэргийн нэмэгдлийн хувь хэмжээг тогтоосон эрх зүйн акт байхгүй учраас байгууллага бүрд харилцан адилгүй хувь хэмжээгээр олгож байгааг харьяалах дээд шатны байгууллагад хүргүүлэх шаардлагатай байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 2,769,236.5 мянган төгрөгийн 1 зөрчил илэрсэнд зөвлөмж өглөө.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 2,066,703.7 мянган төгрөгийн 25 мөнгөн гүйлгээ, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 1,799,143.5 мянган төгрөгийн 101 мөнгөн гүйлгээг, бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийн 165,617.4 мянган төгрөгийн 19 шийдвэрийг хугацаа хоцроож, 2,769,236.5 мянган төгрөгийн 23 шийдвэрийг шилэн дансны цахим хуудаст байршуулаагүй байна.

Дээрх зөрчил нь Шилэн дансны тухай хуулийн 4.1.1 дэх хэсэгт “Мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.3 дахь заалтад “Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх, 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсэгт “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг 7 хоног дотор мэдээлнэ”, 6.4.5 дахь заалтад “Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр”, 6.4.8 дахь заалтад “Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй нь Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Цаашид Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ыг хэрэгжүүлэн ажиллах.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор ирүүлж, биелэлтийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
									Тоо	Дүн	Тоо	Дүн
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
							Тоо	Дүн
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн	1	2,769,236.5					1	2,769,236.5
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн	1	2,769,236.5					1	2,769,236.5

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  М.БАТСУУРЬ/

АУДИТЫН МЕНЕЖЕР

М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР

 9066655 152501/Р. АЮУШ/

2026 оны 02 дугаар сарын 03-ны өдөр